

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАНД ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 01 сарын 15 -ны өдөр

Дугаар ...

БА-010/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол улсын нийслэлийн Баянзүрх дүүргийн 13 дугаар хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын зорьгүй 4 давхар 2 блок 480 (дөрвөн зуун наяд) суудал бүхий хүчин чадалтай сургуулийн зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212-дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗАР

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний дугаар БАЗГ2023/963;

Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс
2023/11/19 өгнөө, 0014250

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар 01/20;

2.3. Захиалагч: Барилга хөгжлийн төв ТӨҮГ оноосон нэр, 9069001077 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9116621 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, III байр, 266282 холбоо барих утас;

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: Юувоку ХХК оноосон нэр, 9011369034 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5631076 регистрийн дугаар, БУ19-552/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 13 дугаар хороо, Сургуулийн 37, 728 А тоот, 99187005, 99195275 холбоо барих утас, youboku999@gmail.com цахим хаяг;

2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: -

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: БАББ ХХК оноосон нэр, 1711003005 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 4124979 регистрийн дугаар, ЗТ38-2123/18 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Монгол даатгал ХХК-ийн байр 208 тоот, 99827967, 99388529 холбоо барих утас, bayartb_73@yahoo.com цахим хаяг;

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори арван дөрөвдүгээр сургууль оноосон нэр, 9070005032 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9096639 регистрийн дугаартай, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13 дугаар хороо, Энхтайваны өргөн чөлөө С14, 11-450785 холбоо барих утас, school_14@edub.edu.mn цахим хаяг;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: Шаардлага хангасан.

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохио зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжинд заасан шаардлагыг хангасан тул

▪ Барилга байгууламжийг ашиглалтанд оруулахаас татгалзах

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохио зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжинд заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэ дунд төвөгшилтэй ангиллын зорьгүй 4 давхар 2 блок 480 (дөрвөн зуун ная) суудал бүхий хүчин чадалтай сургуулийн зориулалттай барилга байгууламжийн ажил түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэхүү барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

- а) Барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагуудад 14 хоногийн дотор багтаан шилжүүлэх
- б) Барилга байгууламжийн ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд хэвийн нөхцлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх

3.3. Ашиглагч байгууллагад:

- а) Барилга байгууламжийн ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох
- б) Барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх
- в) Барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.


3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 6 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 30 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

ХИНАЛТ ША
ГАЗ
Барилга байгуулам
оруулах

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Энэ дунд төвөгшилтэй ангиллын зоорьгүй 4 давхар 2 блок 480 (дөрвөн зуун наяд) суудал бүхий хүчин чадалтай сургуулийн зориулалттай барилга байгууламжид ашиглалтанд оруулах дүгнэлт гаргасан.

Баянзүрх дүүргийн 13 дугаар хороо, Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын захиалагатай, зоорьгүй 4 давхар 2 блок 480 суудалтай сургуулийн барилга




Комиссын дарга:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч




(А.Мөнгөн)

Комиссын нарийн бичгийн дарга:
Барилгын хөгжлийн төвийн
Барилга, байгууламжийн захиалагчийн
хяналтын хэлтсийн инженер



(Л.Хангай)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 13 ДУГААР ХОРОО, БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ ТӨҮГ-
ЫН ЗАХИАЛАГАТАЙ, ЗООРЬГҮЙ 4 ДАВХАР 2 БЛОК 480 СУУДАЛТАЙ
СУРГУУЛИЙН БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ
КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗАР

2024 оны 10 дугаар сарын 08

Улаанбаатар хот

Барилга байгууламжийг ашиглалтанд
оруулах комисс

Баянзүрх дүүргийн 13 дугаар хороо, Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын захиалагатай, зoorьгүй 4 давхар 2 блок 480 суудалтай сургуулийн барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдааг тус барилгын спорт зааланд 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдөр 10 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж 13 цагт дуусав.

Хуралд:

1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга
О.Оджаргал
2. Комиссын нарийн бичгийн дарга: Барилгын хөгжлийн төвийн Барилга, байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн инженер
Л.Хангай
3. Хяналт шалгалтын газрын, Барилгын стандарт, Аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилгын техникийн хяналтын улсын байцаагч
Б.Шинэжаргал
4. Хяналт шалгалтын газрын, Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч
З.Очирпүрэв
5. Нийслэлийн онцгой байдлын газар, Гал түймэртэй тэмцэх хэлтэс, Барилгын зураг төслийн хяналтын ахлах байцаагч, Хошууч
Б.Даваасүрэн
6. Барилгын хөгжлийн төв, Норм, нормативын хэлтэс, Барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах, норм нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн
О.Ундрах
7. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техникийн хяналтын инженер
Б.Цэрэннадмид
8. Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Техник хяналтын инженер
Б.Оргил
9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг Хамгаалах байгууллага, хүртээмжийн үнэлгээний ажилтан
Б.Даваасүрэн
10. Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивын архивч
Н.Өлзийжаргал
11. Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК, Технологийн удирдлага төлөвлөлтийн газар Чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн
Н.Даваадэмид

- | | |
|---|-----------------------------|
| 12. Ус сувгийн удирдах газар,
хэрэглэгчид үйлчлэх төвийн инженер | Ц.Буяннэмэх
Д.Ирмүүнзаяа |
| 13. Нийслэлийн боловсролын газар | |
| 14. Зураг төсөв зохиогч, Барилга архитектур-
Барилга бүтээц ХХК-ийн архитектор | Б.Баярт
Д.Одгэрэл |
| 15. Гүйцэтгэгч Юувोकү ХХК-ийн Захирал | |

ИРЦИЙН БАЙДАЛ:

- Мэдэгдэл хүлээн авсан – 15
- Хүрэлцэн ирсэн – 15
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 15

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Баянзүрх дүүргийн 13 дугаар хороо, Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын захиалагатай, зорьгүй 4 давхар 2 блок 480 суудалтай сургуулийн барилгын ажлын баримт бичгийн бүрдэл, барилгын ажлын гүйцэтгэл нь ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Хяналт шалгалтын газрын, Барилгын стандарт, Аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын байцаагч **Б.Шинэжаргал**:

- Барилгад ашигласан материалын тохирлын гэрчилгээ, улаан журнал, ил далд ажлын акт, бетоны бат бэхийн шинжилгээний бичиг шалгуулах,
- Дутуу хийж гүйцэтгэсэн ажлыг гүйцэтгэж фото зургаар ирүүлэх,
- Зураг төсөл зохиогчийн нэгдсэн дүгнэлтийг шинэчлэн баталгаагуулж ирүүлэх.

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Хяналт шалгалтын газрын, Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч **З.Очирпүрэв**:

- Гадна дулааны худаг 1, 2-р худгуудын цэвэрлэгээг хийж усыг соруулан хэвийн болгох /үл хөдлөх тулгуурыг фото зургаар шалгуулах/,
- Бохир усны худаг цэвэрлэх дулаалгатай таг бүгдэд нь хийх,
- Гал зуухны АС-ийг ажиллагаанд холбож моторын дууг /үйлчилгээний зааланд/ хэмжил хийлгэх,
- Ангиудын халаах хэрэгсэлд термостат бүрэн угсрах,
- Спорт заалны агаар сэлгэлтийн системийн өөрчлөлтийн зураг хийх,
- Узелийн өрөөний халаалтын өргөх насосны дууг багасгах арга хэмжээ авах,
- Дээвэр дээрх үнэр гаргагчид таг хийх,
- Давхруудын 00 өрөөний тосгуур /эрэгтэй/ суултуур зургаас багассан байна,
- Гадна цэвэр бохир дулааны шугам мэдээллийн санд оруулах,

- Цэвэр усны шинжилгээнд хамруулан Эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн дүнэлт гаргуулах.

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Барилгын хөгжлийн төвийн, Барилга, байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн инженер **Л.Хангай**:

- Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх.

Барилгын хөгжлийн төв, Норм, нормативын хэлтэс, Барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах, норм нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн **О.Ундрах**:

- Анги танхим болон нийтийн эзэмшлийн талбайн шатанд ам дарагч хийх,
- Аваарын хаалга болон гадна хаалганд татуурга тоноглолыг хийх,
- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасны дагуу гэрээ байгуулсан төсвийн хүрээнд норм, нормативын төлбөрийг төлөх.

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Техник хяналтын инженер **Б.Оргил**:

- Аж ахуйн гэрээг өргөтгөлийн барилга бүрэн ашиглалтад орсны дараа 14-р сургуулийн нэр дээр шилжүүлэх,
- Дулааны узелийн хаалганд агаар сэлгэх цонх гаргаж өгөх,
- Хэрэглээний халуун усны бойлерын хүчин чадлыг проектын ачааллаас 50% нөөцтэй байхаар ялтас нэмж томруулах,
- Дулааны тоног төхөөрөмжийг цэвэрлэх, хаягжуулалтыг гүйцээж хийх, хэмжих хэрэгслүүдийг баталгаажуулах,
- Үүрэг даалгаврын биелэлтийг “УБДС” ТӨХК-д албан тоотоор өгөх.

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Нийслэлийн онцгой байдлын газар, Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Барилгын зураг төслийн хяналтын ахлах байцаагч, хошууч **Б.Даваасүрэн**:

- ОБГ-аас зураг хянасан дүгнэлт нөхөж үзүүлэх,
- Гадна дулаалгын дүгнэлт нөхөж үзүүлэх,
- Спорт заалны дээврийн сендвич, дээврийн метал хийц шинжилгээний дүгнэлт,
- Автомат галын дохиоллын систем шалгасан акт фото зураг, 24 цагаар хүн байрлах өрөө тасалгааны удирдлагын самбар зааварчилгаа байрлуулах,
- Гал унтраах анхан шатны багаж зэвсэглэмж байрлуулах MNS 5566:2020 стандартын дагуу,
- Цахилгаан ерөнхий щитний өрөөнд галын дохиоллын систем төлөвлөж автомат бие даасан гал унтраах модулын систем төлөвлөх,
- Барилга хоорондын зай хэмжээг хэмжих,

- Шуурхай албаны автомашиныг чөлөөтэй нэвтрэх зай хэмжээ хангах,
- Гидрант төлөвлөх.

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, хүртээмжийн үнэлгээний ажилтан **Б.Даваасүрэн:**

- Гадна авто машины зогсоолд ХБИ-ны авто машинд зориулсан зогсоолыг стандартын дагуу төлөвлөж хийх босоо тэмдэглэгээтэй,
- Гадна хөтөч замыг стандартын дагуу зөв бүтэн хийх, эхлэл төгсгөл эргэлтийг зөв хийх,
- Сургуулийн барилгын 4 талд рампийг стандартын дагуу хийх,
- Гадна үүдний налуу замуудад 2 талдаа ижил бариул хийх бариулын өндөр 70см, жижиг бариул өндөр 50см, бариул хооронд 90см,
- Давхар бүрийн эр, эм нэг АЦӨ-г ХБИ-дэд зориулан тусгай тоноглолоор тоноглох, орон зай гаргах, хаалганы өргөнийг 90см-с багагүй болгож угаалтуур янзлах, стандарт болгох
- Зургийн компани болон сургуулийн захиралаас ХБИ хэрхэн тэгш хүртээмжтэй зорчиж суралцах талаар байобар албан бичиг авах.

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техникийн хяналтын инженер **Б.Цэрэннадмид:**

- Ерөнхий оролтын самбаруудыг ажлын зургийн дагуу зөв бүрэн угсрах, АВР тавих,
- Үндсэн тэжээлийн кабелиудыг холбож, тоолуур хэмжих хэгэрсэл суурилуулах,
- Гадна цахилгааны дэд өртөөний улсын комиссын дүгнэлт, залгах зөвшөөрөл шалгуулах,
- Гадна, дотор цахилгааны угсралтын ил далд ажлын акт шалгуулах,
- Аянгын буулт 0.4кВ-н щитний газардуулгын R хэмжүүлсэн протокол шалгуулах,
- ЕОС, давхрын ХС-уудад хаяг бичиглэл хийж схем байрлуулах,
- Дулааны узелийн тоноглолуудыг газардуулгын хүрээнд холбох,
- Ерөнхий щитний өрөөнд хаяг бичиглэл хийж АА плакат хадах,
- Гадна ЦДКШ-г НМС-д бүртгүүлсэн акт шалгуулах,
- Түр тэжээлийн кабелийг хурааж цэгцлэх.

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивын архивч **Н.Өлзийжаргал:**

- Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэлийг гүйцэтгэгч байгууллага баталгаажуулах,
- Баримт бичгийн бүрдлийг бүрэн бүрдэлтэй бүрдүүлэх,

- Архивд баримт хүлээлгэж өгөх нийтлэг жагсаалтын дагуу эмхлэн цэгцэлж бичвэртэй хуудас бүрийг дугаарлаж, дотоод товъёг үйлдэх,
- Баримтыг цоолж нуруулдах,
- Ажлын зураг болон холбогдох баримт бичгийн эх хувийг архивд хүлээлгэн өгөх,
- Барилга угсралтын явцад авсан гэрэл зургийг нөхөж бүрдүүлэх,
- Барилгад хэрэглэсэн материалын гарал үүслийн гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүнг мөн бүрэн бүрдүүлэх,

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Ус сувгийн удирдах газрын хэрэглэгчид үйлчлэх төвийн инженер **Ц.Буяннэмэх:**

- 2020 онд хянуулсан зураг өөрчлөлттэй байна, 2023 онд техникийн нөхцөл сунгуулсны дагуу дахин ажлын зураг хийлгэж хянуулах шаардлагатай,
- Цэвэр усны худагт техникийн нөхцөлд заасны дагуу галын гидрант суурилуулах шаардлагатай,
- Борооны ус зайлуулах систем хийх /бохир усны системээс тусад нь/,
- Бохир усны худгуудийн ажлын талбайг цэвэрлэх, барилгын гаргалгааны шугамын ажлын талбай хий, засвар үйлчилгээ хийх боломжтой болгож шат хийх,
- Цэвэр усны худагт тогтсон усыг соруулж цэвэрлэх,
- Гал тогооны бохир умны гаргалгаанд тос баригч суурилуулах.

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Мэдээлэл холбоо сүлжээ ХХК-ийн Технологийн удирдлага төлөвлөлтийн газар Чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн **Н.Даваадэмид:**

- Холбооны худгийн таг хүзүүг бэхлэн кабелийн тавиурыг хийж гүйцэтгэх,
- Акт бичиг баримтын бүрдлийг бүрэн хангаж үзүүлэх,
- Галын системийн утаа мэдрэгч ажиллахгүй байгааг бүрэн ажил оруулах,
- Давхарын самбаруудад хаягжилт хийх.

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Нийслэлийн боловсролын газрын мэргэжилтэн **Д.Ирмүүнзаяа:**

- Дотор дутуу ажил хийж дусгах,
- Гадна талбайн ажил дуусгаж цэвэрлэгээ хийх,
- Цахилгаан дулааны төлбөр тооцоо дуусгаж өгөх,
- Холбогдох зураг төсөл бичиг баримт 1% ашиглагчид хүлээлгэн өгөх,
- Барилгын хувийн хэрэг үүсгэж өгөх,
- Дотор засалд улаан өнгө өөрчилж БНБД-н дагуу өөрчлөх.

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

ЛТЫН

ашиглал
сс

Зураг төсөв зохиогч Барилга архитектур-Барилга бүтээц ХХК-ийн архитектур **Б.Баярт:**

- Зураг төслийн дагуу хийгдсэн гэж дүгнээд барилгыг ашиглалтад оруулна.

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Гүйцэтгэгч, Юовоку ХХК-ийн захирал **Д.Одгэрэл:**

- Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлнэ.

Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга **О.Оджаргал:**

- БНБД 11-04-16 дагуу зохиогч дүгнэлт бичих,
- БТХ-ийн дагуу барилгад чанарын баталгаа гаргаж албан тоотоор ирүүлэх,
- Батлагдсан ЗТ-ийн дагуу гадаа тохижилт, ногоон байгууламж дутуу ажлыг бүрэн дуусгах,
- Налуу зам, галын шатны 2 талд бариулыг хийж гүйцэтгэх,
- Дээврийн усны хаялагыг налуу замын төгсгөлөөс холдуулах,
- Заалны халаах хэрэгсэлд хамгаалалт хийх.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Баянзүрх дүүргийн 13 дугаар хороо, Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын захиалагатай, зoorьгүй 4 давхар 2 блок 480 суудалтай сургуулийн барилгыг байнгын ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлтийг баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч



А.Мөнгөн

Тэмдэглэл хөтөлсөн.

Барилгын хөгжлийн төвийн Барилга,
байгууламжийн захиалагчийн
хяналтын хэлтсийн инженер

Л.Хангай